

ТӨВ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2022/21/-НА-СТА-ТШЗ

ТӨВ АЙМАГ ДАХЬ ЦАГДААГИЙН ГАЗРЫН 2021 ОНЫ САНХҮҮГИЙН  
ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН ХИЙСЭН АУДИТЫН  
ТАЙЛАН

Зуунмод 2022 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: [khishigjargalts@audit.gov.mn](mailto:khishigjargalts@audit.gov.mn)

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: [amarjargalo@audit.gov.mn](mailto:amarjargalo@audit.gov.mn)

Аудитор Д.Бямбасүрэн

Утас: 70272287 Цахим хаяг: [byambasurend@audit.gov.mn](mailto:byambasurend@audit.gov.mn)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг  
дараах хаягаар авна уу. Цахим хаяг: [www.audit.mn](http://www.audit.mn)

## **Агуулга**

<u>1. Аудитын санал дүгнэлт</u> .....	3
<u>2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл</u> .....	4-9
<u>3. Аудитын тайлан</u> .....	10
<u>3.1 Ерөнхий зүйл</u> .....	10
<u>3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт</u> .....	10
<u>3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал</u> .....	11
<u>3.4 Материаллаг байдал</u> .....	11
<u>3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга</u> .....	12
<u>3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв</u> .....	12
<u>3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг</u> .....	14
<u>3.8 Аудитын гол асуудал</u> .....	14
<u>3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал</u> .....	15
<u>3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт</u> .....	15
<u>3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал</u> .....	15
<u>4. Аудитын илрүүлэлт</u> .....	15
<u>5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл</u> .....	16

### **Товчилсон үгийн жагсаалт**

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн Өмчийн Бодлого Зохицуулалтын Газар



**ТӨВ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

41100 Зуунмод, Төв аймаг  
Утас: 70272248, Факс: 70272582, И-мэйл: tuv@audit.gov.mn

дэлг. № 02.16 № 01/35  
танай -ны № -т

ТӨВ АЙМАГ ДАХЬ ЦАГДААГИЙН  
ГАЗРЫН ДАРГА, ЦАГДААГИЙН ДЭД  
ХУРАНДАА Ч.АЛТАНХУЯГ ТАНАА

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төв аймаг дахь Цагдаагийн газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Төв аймаг дахь Цагдаагийн газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ  
19020192

D 2022/2022 он/ALBAN BICHIG

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/			
Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>306,302,911.24</b>	<b>257,531,387.99</b>
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	306,302,911.24	257,531,387.99
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	149,256,045.80	118,533,552.16
35110	Тусгай зориулалттай материал	147,173,095.80	114,404,023.46
35130	Эм боох материал	2,082,950.00	4,129,528.70
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	122,701,385.44	109,505,609.83
35410	Бичиг хэргийн материал	16,458,230.00	2,156,506.00
35420	Ажахуйн материал	3,903,037.00	4,655,700.00
35440	Түлш, шатах тослох материал	1,200,000.00	00.00
35470	Бусад хангамжийн материал	101,140,118.44	102,693,403.83
35600	Мал амьтад	34,345,480.00	29,492,226.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>1,381,697,569.81</b>	<b>1,186,439,700.47</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	1,381,697,569.81	1,186,439,700.47
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	1,069,553,819.81	866,136,950.47
39201	Барилга, байгууламж орон сууц	994,875,085.80	979,988,020.80
39202	Хуримтлагдсан элэгдэл	-726,409,980.58	-806,096,606.79
39203	Авто-тээврийн хэрэгсэл	644,982,681.44	773,176,898.07
39204	Хуримтлагдсан элэгдэл	-314,505,550.96	-437,272,301.90
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	492,769,754.94	528,089,698.29
39206	Хуримтлагдсан элэгдэл	-165,244,734.68	-289,737,227.28
39207	Тавилга, ажахуйн эд хогшил	93,164,828.22	86,131,339.53
39208	Хуримтлагдсан элэгдэл	-54,110,670.13	-58,508,283.28
39211	Батлан хамгаалах, цэргийн зориулалттай тоног төхөөрөмж	62,057,324.00	62,057,324.00
39214	Бусад үндсэн хөрөнгө	52,014,729.68	49,062,353.43
39215	Хуримтлагдсан элэгдэл	-10,039,647.92	-20,754,264.40
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	312,143,750.00	320,302,750.00
39301	Програм хангамж	300,000.00	300,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-56,250.00	-131,250.00
39303	Бусад биет бус хөрөнгө	311,900,000.00	320,134,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>1,688,000,481.05</b>	<b>1,443,971,088.46</b>
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>1,688,000,481.05</b>	<b>1,443,971,088.46</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	1,688,000,481.05	1,443,971,088.46
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,514,399,652.56	1,522,633,652.56
51101	Өмч: - төрийн	1,514,399,652.56	1,522,633,652.56
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	-493,748,190.11	-718,267,628.70
51210	Өмнөх үеийн үр дүн	-493,748,190.11	-465,133,076.11
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-253,134,552.59
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	667,349,018.60	639,605,064.60
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>1,688,000,481.05</b>	<b>1,443,971,088.46</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл /Төгрөгөөр/
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>4,193,799,202.40</b>	<b>4,147,853,516.51</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>496,053,472.40</b>	<b>236,479,986.51</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>496,053,472.40</b>	<b>236,479,986.51</b>
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	256,289,055.51	80,035,268.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	23,126,490.31	22,055,790.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	233,162,565.20	57,979,478.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого /үндсэн хөрөнгө/	179,772,137.71	132,004,214.68
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого /бараа материал/	59,992,279.18	24,440,503.83
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>3,697,745,730.00</b>	<b>3,911,373,530.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>3,644,431,000.00</b>	<b>3,878,877,300.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	3,644,431,000.00	3,878,877,300.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>53,314,730.00</b>	<b>32,496,230.00</b>
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	34,201,120.00	10,301,300.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	19,113,610.00	22,194,930.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>4,072,068,843.93</b>	<b>4,396,916,248.01</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>4,072,068,843.93</b>	<b>4,396,916,248.01</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>4,054,532,366.62</b>	<b>4,387,210,361.01</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>3,126,180,700.00</b>	<b>3,358,586,650.00</b>
210101	Үндсэн цалин	1,584,547,105.00	1,641,928,352.00
210102	Нэмэгдэл	1,541,633,595.00	1,716,658,298.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>67,215,569.00</b>	<b>70,415,310.00</b>
210201	Тэтгэврийн даатгал	3,927,168.00	3,104,616.00
210202	Тэтгэмжийн даатгал	462,019.00	343,505.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	369,617.00	274,804.00
210204	Ажилгүйдлийн даатгал	92,405.00	55,355.00
210205	Эрүүл мэндийн даатгал	62,364,360.00	66,637,030.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>144,195,004.00</b>	<b>157,294,900.00</b>
210301	Гэрэл, цахилгаан	16,368,140.00	18,977,187.00
210302	Түлш, халаалт	119,917,121.00	129,461,843.00
210303	Цэвэр, бохир ус	7,909,743.00	8,855,870.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>252,210,442.12</b>	<b>285,558,463.40</b>
210401	Бичиг хэрэг	15,110,069.62	15,589,406.00
210402	Тээвэр, шатахуун	185,355,539.50	169,522,779.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	20,224,567.00	22,116,667.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	660,000.00	660,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	9,198,150.00	14,590,657.00
210408	Бараа материал ахталсны зардал	21,662,116.00	63,078,954.40
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>36,058,471.00</b>	<b>30,114,721.30</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	212,065.00	265,101.30
210502	Хоол, хүнс	35,846,406.00	29,849,620.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>58,868,024.68</b>	<b>49,262,090.00</b>
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	13,295,341.68	2,333,100.00
210604	Урсгал засвар	45,572,683.00	46,928,990.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>28,333,000.00</b>	<b>22,877,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	28,333,000.00	22,877,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>13,527,411.00</b>	<b>18,825,582.38</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	10,600,000.00	15,917,700.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	1,295,000.00	984,908.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	176,000.00	429,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	379,500.00	00.00
210807	Газрын төлбөр	935,700.00	935,700.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	141,211.00	558,274.38
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>327,943,744.82</b>	<b>394,275,643.93</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	00.00	5,580,851.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	735,104.00	712,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	327,208,640.82	387,982,792.93
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>17,536,477.31</b>	<b>9,705,887.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>9,655,612.00</b>	<b>7,380,000.00</b>
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	500,000.00	500,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	9,155,612.00	6,880,000.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>7,880,865.31</b>	<b>2,325,887.00</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	7,875,865.31	2,325,887.00
213304	Төвлөрүүлэх шилжүүлэг нэмэлт	5,000.00	00.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>121,730,358.47</b>	<b>-249,062,731.50</b>
<b>225</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>2,385,264.88</b>	<b>4,071,821.09</b>
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	2,385,264.88	4,047,621.09
225011	Үнэ төлбөргүй шилүүүлсэн бараа материал	00.00	24,200.00
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	<b>-2,385,264.88</b>	<b>-4,071,821.09</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>119,345,093.59</b>	<b>-253,134,552.59</b>

### 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	<b>2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>1,514,399,652.56</b>	<b>725,225,385.16</b>	<b>-670,969,650.26</b>	<b>00.00</b>	<b>1,568,655,387.46</b>
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	57,876,366.56	00.00	57,876,366.56
C03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>1,514,399,652.56</b>	<b>725,225,385.16</b>	<b>-613,093,283.70</b>	<b>00.00</b>	<b>1,626,531,754.02</b>
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	-57,876,366.56	00.00	00.00	-57,876,366.56
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	119,345,093.59	00.00	119,345,093.59
C08	<b>2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>1,514,399,652.56</b>	<b>667,349,018.60</b>	<b>-493,748,190.11</b>	<b>00.00</b>	<b>1,688,000,481.05</b>
D01	<b>2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл</b>	<b>1,514,399,652.56</b>	<b>667,349,018.60</b>	<b>-493,748,190.11</b>	<b>00.00</b>	<b>1,688,000,481.05</b>
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	28,615,114.00	00.00	28,615,114.00
D03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>1,514,399,652.56</b>	<b>667,349,018.60</b>	<b>-465,133,076.11</b>	<b>00.00</b>	<b>1,716,615,595.05</b>
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	-27,743,954.00	00.00	00.00	-27,743,954.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	8,234,000.00	00.00	00.00	00.00	8,234,000.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-253,134,552.59	00.00	-253,134,552.59
D09	<b>2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>1,522,633,652.56</b>	<b>639,605,064.60</b>	<b>-718,267,628.70</b>	<b>00.00</b>	<b>1,443,971,088.46</b>

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>3,721,936,330.31</b>	<b>3,934,699,417.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>24,190,600.31</b>	<b>23,325,887.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>24,190,600.31</b>	<b>23,325,887.00</b>
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	24,190,600.31	23,325,887.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	24,190,600.31	23,325,887.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>3,697,745,730.00</b>	<b>3,911,373,530.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>3,644,431,000.00</b>	<b>3,878,877,300.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	3,644,431,000.00	3,878,877,300.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>53,314,730.00</b>	<b>32,496,230.00</b>
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	34,201,120.00	10,301,300.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	19,113,610.00	22,194,930.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>3,683,548,491.31</b>	<b>3,928,165,087.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>3,683,548,491.31</b>	<b>3,928,165,087.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>3,669,287,626.00</b>	<b>3,918,459,200.00</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>3,126,573,500.00</b>	<b>3,360,264,700.00</b>
210101	Үндсэн цалин	1,889,248,300.00	1,930,737,000.00
210102	Нэмэгдэл	1,237,325,200.00	1,429,527,700.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>67,774,735.00</b>	<b>70,589,900.00</b>
210205	Эрүүл мэндийн даатгал	67,774,735.00	70,589,900.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>144,455,571.00</b>	<b>157,294,900.00</b>
210301	Гэрэл, цахилгаан	16,368,140.00	17,680,145.00
210302	Түлш, халаалт	119,917,121.00	130,758,885.00
210303	Цэвэр, бохир ус	8,170,310.00	8,855,870.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>198,308,520.00</b>	<b>199,006,520.00</b>
210401	Бичиг хэрэг	13,817,000.00	13,256,980.00
210402	Тээвэр, шатахуун	156,525,520.00	155,384,943.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	19,964,000.00	24,049,067.00
210404	Ном, хэвлэл	120,000.00	20,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	660,000.00	660,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	7,222,000.00	5,635,530.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>37,470,000.00</b>	<b>30,275,000.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	200,000.00	300,000.00
210502	Хоол, хүнс	35,770,000.00	29,850,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,500,000.00	125,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>51,440,100.00</b>	<b>58,212,280.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	630,100.00	1,312,280.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	4,000,000.00	4,390,000.00
210604	Урсгал засвар	46,810,000.00	52,510,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>28,333,000.00</b>	<b>22,877,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	28,333,000.00	22,877,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>13,386,200.00</b>	<b>17,980,400.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	10,600,000.00	15,085,700.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	1,295,000.00	1,295,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	176,000.00	664,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	379,500.00	00.00
210807	Газрын төлбөр	935,700.00	935,700.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>1,546,000.00</b>	<b>1,958,500.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	00.00	500,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,546,000.00	1,458,500.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>14,260,865.31</b>	<b>9,705,887.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>6,380,000.00</b>	<b>7,380,000.00</b>
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	500,000.00	500,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	5,880,000.00	6,880,000.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>7,880,865.31</b>	<b>2,325,887.00</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	7,875,865.31	2,325,887.00
213304	Төвлөрүүлэх шилжүүлэг нэмэлт	5,000.00	00.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>38,387,839.00</b>	<b>6,534,330.00</b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>38,387,839.00</b>	<b>6,534,330.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>38,387,839.00</b>	<b>6,534,330.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>38,387,839.00</b>	<b>6,534,330.00</b>
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	38,387,839.00	6,534,330.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b>-38,387,839.00</b>	<b>-6,534,330.00</b>

Төв аймаг дахь Цагдаагийн газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Үзүүлэлт	Өмнөх оны		Тайлант оны		Хэтрэлт - Хэмнэлт +
	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл					
<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>3,667,431,000.00</b>	<b>3,660,745,735.00</b>	<b>3,899,877,300.00</b>	<b>3,899,877,300.00</b>	<b>0.00</b>
<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>3,667,431,000.00</b>	<b>3,660,745,735.00</b>	<b>3,899,877,300.00</b>	<b>3,899,877,300.00</b>	<b>0.00</b>
<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>3,661,051,000.00</b>	<b>3,654,365,735.00</b>	<b>3,892,497,300.00</b>	<b>3,892,497,300.00</b>	<b>0.00</b>
<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>3,126,573,500.00</b>	<b>3,126,573,500.00</b>	<b>3,360,264,700.00</b>	<b>3,360,264,700.00</b>	<b>0.00</b>
Үндсэн цалин	1,892,733,100.00	1,892,733,100.00	1,930,737,000.00	1,930,737,000.00	0.00
Нэмэгдэл	1,233,840,400.00	1,233,840,400.00	1,429,527,700.00	1,429,527,700.00	0.00
<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>74,460,000.00</b>	<b>67,774,735.00</b>	<b>70,589,900.00</b>	<b>70,589,900.00</b>	<b>0.00</b>
Эрүүл мэндийн даатгал	74,460,000.00	67,774,735.00	70,589,900.00	70,589,900.00	0.00
<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>142,713,900.00</b>	<b>142,713,900.00</b>	<b>157,294,900.00</b>	<b>157,294,900.00</b>	<b>0.00</b>
Гэрэл, цахилгаан	15,081,300.00	15,081,300.00	16,707,300.00	17,680,145.00	-972,845.00
Түлш, халаалт	119,687,600.00	119,687,600.00	131,267,600.00	130,758,885.00	508,715.00
Цэвэр, бохир ус	7,945,000.00	7,945,000.00	9,320,000.00	8,855,870.00	464,130.00
<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>186,532,400.00</b>	<b>186,532,400.00</b>	<b>188,215,400.00</b>	<b>188,215,400.00</b>	<b>0.00</b>
Бичиг хэрэг	13,907,000.00	13,907,000.00	13,907,000.00	13,214,980.00	692,020.00
Тээвэр, шатахуун	146,486,400.00	146,486,400.00	149,086,400.00	145,098,643.00	3,987,757.00
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	19,942,000.00	19,942,000.00	19,942,000.00	23,361,347.00	-3,419,347.00
Ном, хэвлэл	120,000.00	120,000.00	120,000.00	20,000.00	100,000.00
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	660,000.00	660,000.00	660,000.00	660,000.00	0.00
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,417,000.00	5,417,000.00	4,500,000.00	5,860,430.00	-1,360,430.00
<b>Нормативт зардал</b>	<b>34,800,000.00</b>	<b>34,800,000.00</b>	<b>29,525,000.00</b>	<b>29,525,000.00</b>	<b>0.00</b>
Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	200,000.00	200,000.00	300,000.00	300,000.00	0.00
Хоол, хүнс	33,100,000.00	33,100,000.00	29,100,000.00	29,100,000.00	0.00
Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,500,000.00	1,500,000.00	125,000.00	125,000.00	0.00
<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>58,010,000.00</b>	<b>58,010,000.00</b>	<b>56,510,000.00</b>	<b>56,510,000.00</b>	<b>0.00</b>
Багаж, техник, хэрэгсэл	7,200,000.00	7,200,000.00	0.00	0.00	0.00
Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл	4,000,000.00	4,000,000.00	4,000,000.00	4,000,000.00	0.00
Урсгал засвар	46,810,000.00	46,810,000.00	52,510,000.00	52,510,000.00	0.00
<b>Томилолт, зочны зардал</b>	<b>22,525,000.00</b>	<b>22,525,000.00</b>	<b>12,317,000.00</b>	<b>12,317,000.00</b>	<b>0.00</b>
Дотоод албан томилолт	22,525,000.00	22,525,000.00	12,317,000.00	12,317,000.00	0.00
<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>12,786,200.00</b>	<b>12,786,200.00</b>	<b>15,280,400.00</b>	<b>15,280,400.00</b>	<b>0.00</b>
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	10,000,000.00	10,000,000.00	12,385,700.00	12,385,700.00	0.00
Тээврийн хэрэгслийн татвар	1,295,000.00	1,295,000.00	1,295,000.00	1,295,000.00	0.00
Тээврийн хэрэгслийн оношлогоо	176,000.00	176,000.00	664,000.00	664,000.00	0.00
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	379,500.00	379,500.00	0.00	0.00	0.00
Газрын төлбөр	935,700.00	935,700.00	935,700.00	935,700.00	0.00
<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>2,650,000.00</b>	<b>2,650,000.00</b>	<b>250,000.00</b>	<b>250,000.00</b>	<b>0.00</b>
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,650,000.00	2,650,000.00	2,500,000.00	2,500,000.00	0.00
<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>6,380,000.00</b>	<b>6,380,001.00</b>	<b>7,380,000.00</b>	<b>7,380,000.00</b>	<b>0.00</b>
<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>6,380,000.00</b>	<b>6,380,000.00</b>	<b>7,380,000.00</b>	<b>7,380,000.00</b>	<b>0.00</b>
Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	500,000.00	500,000.00	500,000.00	500,000.00	0.00
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	5,880,000.00	5,880,000.00	6,880,000.00	6,880,000.00	0.00
<b>ЗАРДЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>3,667,431,000.00</b>	<b>3,661,936,335.31</b>	<b>3,899,877,300.00</b>	<b>3,899,877,300.00</b>	<b>0.00</b>
<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>3,644,431,000.00</b>	<b>3,637,745,735.00</b>	<b>3,878,877,300.00</b>	<b>3,876,551,413.00</b>	<b>2,325,887.00</b>
Улсын төсвөөс санхүүжих	3,644,431,000.00	3,637,745,735.00	3,878,877,300.00	3,876,551,413.00	2,325,887.00
<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	<b>23,000,000.00</b>	<b>24,190,600.31</b>	<b>21,000,000.00</b>	<b>22,055,790.00</b>	<b>-1,055,790.00</b>
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	23,000,000.00	24,190,600.31	21,000,000.00	22,055,790.00	-1,055,790.00
<b>БУСАД ЭХ ҮҮСВЭР</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>	<b>1,270,097.00</b>	<b>-1,270,097.00</b>
Бусад орлого				1,270,097.00	-1,270,097.00
<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	<b>01.00</b>	<b>01.00</b>	<b>01.00</b>	<b>01.00</b>	
Төсвийн байгууллага	01.00	01.00	00.00	01.00	
Төсвөөс гадур байгууллага	00.00	00.00	00.00	00.00	
<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	<b>222.00</b>	<b>216.00</b>	<b>222.00</b>	<b>217.00</b>	
Удирдах ажилтан	02.00	02.00	02.00	02.00	
Гүйцэтгэх ажилтан	217.00	210.00	217.00	211.00	
Үйлчлэх ажилтан	03.00	04.00	03.00	04.00	

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	/ төгрөгөөр /	
		Өмнөх он	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>53,314,730.0</b>	<b>32,496,230.0</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>53,314,730.0</b>	<b>32,496,230.0</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>53,309,730.0</b>	<b>32,496,230.0</b>
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>12,254,120.0</b>	<b>11,016,020.0</b>
210401	Бичиг хэрэг	188,000.0	42,000.0
210402	Тээвэр, шатахуун	10,039,120.0	10,286,300.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	22,000.0	687,720.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,005,000.0	750,000.0
210502	Хоол, хүнс	2,670,000.0	750,000.0
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>30,235,939.0</b>	<b>6,970,210.0</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	28,061,000.0	5,312,280.0
210602	Тавилга	1,580,939.0	1,267,930.0
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	594,000.0	390,000.0
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>5,808,000.0</b>	<b>10,560,000.0</b>
210702	Дотоод албан томилолт	5,808,000.0	10,560,000.0
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>600,000.0</b>	<b>2,700,000.0</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	600,000.0	2,700,000.0
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>-</b>	<b>500,000.0</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		500,000.0
213503	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг	5,000.0	-
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>53,314,730.0</b>	<b>32,491,230.0</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>53,314,730.0</b>	<b>32,491,230.0</b>
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	34,201,120.0	10,296,300.0
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	19,113,610.0	22,194,930.0

### **3. Аудитын тайлан**

#### **3.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Төв аймаг дахь Цагдаагийн газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд төсвийн төлөвлөлт, худалдан авалттай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Төв аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Д.Бямбасүрэн гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер О.Амаржаргал, дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв аймаг дахь Цагдаагийн газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 24-ны өдрийн 43/01-349 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

#### **3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт**

Төв аймаг дахь Цагдаагийн газар нь гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үндсэн чиг үүргийг хуульд заасан бүрэн эрхийн хүрээнд хэрэгжүүлэх төрийн тусгай алба юм.

Төв аймаг дахь Цагдаагийн газрын тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Төв аймаг дахь Цагдаагийн газрын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Төв аймгийн Цагдаагийн газрын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Төв аймаг дахь Цагдаагийн Газрын даргын 2021 оны 01 дүгээр сарын 19-ны өдрийн А/02 тоот тушаалаар 13 хүний бүрэлдэхүүнтэй дотоод хяналт шалгалт явуулах ажлын хэсгийг байгуулж шалгалт явуулах хуваарийг баталсан байна. Цагдаагийн Ерөнхий Газрын даргын 2017 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн А/246 дугаар тушаалаар

баталсан Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам "Байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт, шалгалт зохион байгуулах код-112"-ийг удирдлага болгон цагдаагийн газрын хэлтэс, тасаг, хэсгийн үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг явуулсан байна.

Төв аймаг дахь Цагдаагийн газрын дотоод хяналтын ажлын хэсэг нь хэлтэс, тасаг, хэсгүүдэд 11 үзүүлэлтээр дотоод хяналт хийх төлөвлөгөө гаргасны дагуу шалгалт хийж, шалгалтын дүнг Цагдаагийн газрын даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн илэрсэн зөрчлийг арилгах талаар хугацаатай үүрэг өгч биелэлтийг тооцож ажилласан байна.

Төв аймаг дахь Цагдаагийн газрын 2020 оны санхүүгийн үйл ажиллагаанд Цагдаагийн ерөнхий газраас төлөвлөгөөт санхүүгийн хяналт шалгалт хийхэд хангалттай, аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанаас 2019-2020 оны санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийхэд бага эрсдэлтэй дүгнэлт авсан байна.

Төв аймаг дахь Цагдаагийн газрын дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төв аймаг дахь Цагдаагийн газрын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### **3.4 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зарлагыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл "дунд" гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн тайлангийн нийт зарлагын 4,072.1 сая төгрөгөөс 1 хувиар буюу 40.7 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 28.5 сая төгрөгөөр тогтоосон.

Төв аймаг дахь Цагдаагийн газрын төлөвлөх үе шатанд материаллаг байдлын суурь үзүүлэлтийг 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн мэдээллээр тооцсон тул гүйцэтгэлийн үе шатанд 2021 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаас дахин тооцлоо.

Гүйцэтгэлийн үе шатанд шинэчлэн тогтоосон материаллаг байдлын түвшин 43.9 сая төгрөг, энэ нь төлөвлөлтийн үе шатнаас 3.2 сая төгрөгөөр өссөн байна. Гүйцэтгэлийн материаллаг байдлыг 30.8 сая төгрөгөөр тогтоогдсон байна.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Энэхүү Санхүүгийн тайлангаар Төв аймаг дахь Цагдаагийн газрын 2021 оны санхүүгийн байдал, үйл ажиллагааны үр дүнг толилуулж байна. Монгол Улсын Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3, 4.4 дэх заалтыг үндэслэн Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт (УСНББОУС) болон Монгол Улсын холбогдох хууль, журам, заавар, Цагдаагийн байгууллагад мөрдөгдөх Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт нийцүүлэн санхүүгийн тайланг бэлтгэсэн байна.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартад шаардсан зарчмын дагуу нягтлан бодох бүртгэлийн аккруэл сууриар бэлтгэн тайлагнасан байна.

#### **Орлого:**

Тус байгууллага 2021 онд улсын төсвөөс 3,878.9 сая төгрөг, төсөвт байгууллагын өөрийн орлого 80.0 сая төгрөг, үнэ төлбөргүй хүлээн авсан орлого 156.4 сая төгрөг нийт 4,147.9 сая төгрөг өмнөх оноос 45.9 сая төгрөгөөр буюу 1.1 хувиар буурсан байна.

#### **Зардал:**

Төв аймаг дахь Цагдаагийн газар 2021 оны санхүүгийн тайлангийн үр дүнгийн тайлангаар 4,396.9 сая төгрөг, мөнгөн гүйлгээний тайлангаар 3,928.1 сая төгрөг, төсвийн гүйцэтгэлийн тайлангаар 3,899.9 сая төгрөг зарцуулсан байна.

#### **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө:**

Тус байгууллага төрийн сангийн 100140012001 тоот дансанд 2021 онд 3,911.8 сая төгрөгийн орлого, 3,911.8 сая төгрөгийн зарлагын гүйлгээ хийгдэж, 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн үлдэгдэл 0 төгрөг байна. Мөн нэмэлт санхүүжилтийн 100140012402 тоот дансанд 32.5 сая төгрөгийн орлого төвлөрч, 32.5 сая төгрөгийн зарлагын гүйлгээ хийгдэж үлдэгдэл 0 төгрөг байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/сая.төгрөг/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
<b>Б</b>	<b>1</b>	<b>2</b>	<b>3=2-1</b>
Мөнгөн хөрөнгө			
Авлага	0	0	0
Урьдчилгаа			
Бараа материал	306.3	257.5	-48.8
Үндсэн хөрөнгө	1,381.7	1,186.4	-195.3
Нийт хөрөнгө	1,688.0	1,443.9	-244.1
Өр төлбөр			
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	1,688.0	1,443.9	-244.1
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,688.0	1,443.9	-244.1

Бараа материалын дансны үлдэгдэл 257.5 сая төгрөг болж 48.8 сая төгрөгөөр буурсан нь бараа материал ақталснаас шалтгаалсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,186.4 сая төгрөг болж 244.1 сая төгрөгөөр буурсан нь үндсэн хөрөнгө ақталсан болон элэгдлийн зардлаас шалтгаалсан байна.

Үндсэн хөрөнгийн данс нь урсгал төсвийн худалдан авалтаар 6.5 сая төгрөг, үнэ төлбөргүй шилжиж ирсэн 132.0 сая төгрөг, бусад 58.2 сая төгрөгийн хөрөнгөөр нэмэгдэж, ақталсан 49.5 сая төгрөгийн хөрөнгөөр хасагдсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,443.9 сая төгрөг болж 244.1 сая төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

### **3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.6.1 Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 4,585.3 сая төгрөгөөр, бараа үйлчилгээний нийт зарлагыг 4,585.3 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 685.4 сая төгрөгөөр бууруулж улсын төсвөөс 3,878.9 сая төгрөг, үндсэн үйл ажиллагааны орлогоос 21.0 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр баталсан байна. Энэ нь байр ашиглахтай холбоотой зардал, хангамж бараа материалын зардал, нормативт зардал, эд хогшил урсгал засварын зардал, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардлыг бууруулсантай холбоотой байна.

#### **3.6.2 Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 2 хөтөлбөрийн 3 арга хэмжээг санхүүжүүлэхээр 3,899.9 сая төгрөгийн төсөв баталснаас 3,878.9 сая төгрөгийг улсын төсвөөс 21.0 сая төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоор санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 3,878.9 сая төгрөгийн санхүүжилт авч, үндсэн үйл ажиллагааны орлого 22.0 сая төгрөг, бусад эх үүсвэрээс 1.3 сая төгрөг нийт 3,902.2 сая төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 3,899.9 сая төгрөгийг зарцуулж, 2.3 сая төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 3,899.9 сая төгрөг буюу 99,94 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны орлого 1.0 сая төгрөг, бусад орлого 1.3 сая төгрөг буюу төлөвлөгөөнөөс илүү бүрдүүлсэн 2.3 сая төгрөгийг буцаан төвлөрүүлж зарцуулаагүйтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### **3.6.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Төв аймаг дахь Цагдаагийн газар тайлант онд Аймгийн Засаг даргын Тамгын газраас 11.8 сая төгрөг, Аймгийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлөөс 8.6 сая төгрөг, Онцгой байдлын газраас 8.8 сая төгрөг, өөрийн орлого 3.3 сая төгрөг нийт 32.5 сая төгрөгийн орлого бүрдүүлжээ.

Үүнээс хангамж бараа материалын зардалд 11.0 сая төгрөг, нормативт зардалд 0.7 сая төгрөг, эд хогшил худалдан авах зардалд 7.0 сая төгрөг, томилолтын зардалд 10.6 сая төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардалд 2.7 сая төгрөг, бараа үйлчилгээний бусад зардалд 0.5 сая төгрөг нийт 32.5 сая төгрөгийг зарцуулжээ.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### **3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

Төв аймаг дахь Цагдаагийн газар улсын төсвийн хөрөнгөөр 4.2 сая төгрөгийн тоног төхөөрөмж, 2.3 сая төгрөгийн тавилга хэрэгсэл худалдан авсан, Цагдаагийн ерөнхий газраас 92.2 сая төгрөгийн тээврийн хэрэгсэл, 39.8 сая төгрөгийн тоног төхөөрөмж, малын хулгайн гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр аймгийн хөрөнгө оруулалтаар 50.0 сая төгрөгийн тээврийн хэрэгсэл, 8.2 сая төгрөгийн бусад хөрөнгийг үнэ төлбөргүй шилжүүлэн авч санхүүгийн тайланд тайлагнасан байна.

Төв аймаг дахь Цагдаагийн газар тайлант онд Онцгой байдлын газраас 2.9 сая төгрөгийн бараа материал, НИК ХХК-аас 3.3 сая төгрөгийн шатахууны урамшууллын талон, Цагдаагийн ерөнхий газраас 21.5 сая төгрөгийн бараа материал хүлээн авч тайлагнасан байна.

Орчин цагийн Цагдаагийн байгууллага үүсч хөгжсөний 100 жилийн ой 2021 оны 9 дүгээр сарын 15-нд болсон байна. Цагдаагийн байгууллагын түүхт 100 жилийн ой угтсан бүтээлч ажлын хүрээнд цагдаагийн газрын гадна гэрэлтүүлэгт 5.6 сая төгрөг, албан конторын 1, 2 давхрын коридор, ариун цэврийн өрөө, шатны хонгилыг 23.8 сая төгрөгийн засвар үйлчилгээ хийхэд зарцуулсан байна.

Нутгийн захиргааны байгууллагад хандан 2022 онд Цагдаагийн газарт шинээр баригдах конторын барилгын зургийн дагуу төсөв хийлгэх асуудлыг шийдвэрлүүлэхээр төлөвлөж, энэ нь стандартын шаардлагад нийцсэн, алба хаагчид эрүүл, стандартын шаардлага хангасан албаны байранд ажил үүргээ гүйцэтгэх боломжоор хангагдана гэж үзсэн байна.

### **3.8 Аудитын гол асуудал**

Төв аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл, Аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд, Ковид-19 цар тахал, устгал нэгдсэн арга хэмжээний зардалд 10.3 сая төгрөгийн шатахуун, 10.6 сая төгрөгийн томилолт, хоол хүнс, шуудан холбооны зардалд 0.8 сая төгрөг, халдвар хамгааллын хувцас хэрэгсэл, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардалд 3.0 сая

төгрөг, шаардлагатай техник хэрэгсэл, тоног төхөөрөмж авахад 4.0 сая төгрөг, Цагдаагийн газрын давсан орлогоос 3.8 сая төгрөгийг тус тус зарцуулжээ.

### **3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### **3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 132 мэдээллээс хугацаандаа оруулсан 132 мэдээлэл, хугацаа хоцроосон мэдээлэл байхгүй байна. Тус байгууллага 5,0 саяас дээших орлогын 26, зарлагын 23 гүйлгээ байршуулж, 5,0 саяас дээших худалдан авалтын 81 гүйлгээ байршуулсан байна.

#### **3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Төв аймаг дахь Цагдаагийн газар нь нэмэлт санхүүжилтийн дансаар зарцуулсан 32.5 сая төгрөгийг бусад хууль тогтоомжийн хүрээнд зарцуулан тайлагнасан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, нэмэлт санхүүжилтээр зарцуулсан хөрөнгө, үнэ төлбөргүй хүлээн авсан орлогууд бусад хууль тогтоомжийн хүрээнд нийцсэн байна гэж дүгнэлээ.

#### **3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Тус байгууллага 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар шилэн дансны цахим сайтад мэдээллийг хуулийн хугацаанд байршуулж мэдээлэх, е-баримтын худалдан авалт, хууль тогтоомжтой холбоотой 3 зөвлөмжийг 100% хэрэгжүүлэн ажиллаж Цагдаагийн газрын даргын 2021 оны 6 дугаар сарын 03-ны өдрийн 43/01-1781 тоот албан бичгээр гарган ирүүлсэн байна.

#### **3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Ахмадын сангийн дансанд төвлөрүүлж байгаа зардлыг дараагийн аудитаар анхаарах.

### **4. Аудитын илрүүлэлт**

Аудитаар нийт 5.5 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 3.3 сая төгрөгийн алдааг залруулж, 2.2 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж өгөв.

#### 4.1 Залруулсан алдаа

Тус байгууллага санхүүгийн өмнөх оны үр дүнгийн тайланд бараа ажил үйлчилгээний зардлыг 3.3 сая төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 5.1.3-д жинхэнэ хэрэгжилтийн зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлнө” гэж заасныг болон санхүүгийн тайлангийн “тохиолдсон байх”, “үнэн зөв байдал” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулга хийгдсэн.

#### 4.2.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

##### 1. Төсвийн гүйцэтгэлтэй холбоотой асуудал

###### 1.1. Илрүүлэлт:

Тус байгууллага тайлант онд Цагдаагийн Ерөнхий Газрын Санхүү аж ахуйн албаны даргын 2021 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн 6/1865 тоот албан бичиг ирүүлсний дагуу Цагдаагийн Ерөнхий газрын Ахмадын сангийн төрийн сан банкин дах 100900012545 тоот дансанд 2.2 сая төгрөгийг 4 зардлаас түүвэрлэн улсын төсөвт төвлөрүүлэхгүйгээр шилжүүлсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-д “Хариуцлагатай байх”, мөн хуулийн 45 дугаар зүйлийн 45.2-т “Төсвийн захирагчийн төсвийн дараах зарцуулагдаагүй үлдэгдлийг төсвийн хэмнэлтэд тооцохгүй бөгөөд тухайн үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд төвлөрүүлнэ” гэж заасныг болон Санхүүгийн тайлангийн “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй зөрчсөн байна.

###### 1.2. Өгсөн зөвлөмж:

- Цаашид ахмадын санд төсвөөс зардлыг зарцуулж санхүүжүүлэхгүй байх, холбогдох хууль тогтоомж мөрдөж ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 6 дугаар сарын 20 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

#### 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа зөрчил		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	дүн	Тоо	дүн	Тоо	дүн	Тоо	дүн	Тоо	дүн
1	Цагдаагийн газар	2	5.5	1	3.3	0	0	0	0	1	2.2

Монгол улс, Төв аймаг, Зуунмод сум  
6 дугаар баг, Төрийн захиргааны 2 байр  
Утас: +976 70272582, +976 70272287  
И –мэйл: [tuv@audit.gov.mn](mailto:tuv@audit.gov.mn), Вебсайт: [www.audit.mn](http://www.audit.mn)